



ХӨВСГӨЛ АЙМАГ  
ЦАГААН-УУЛ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2015 оны 05 сарын 29 өдөр

Дугаар 23

Шарга

Шинэ дуганын ажлыг эрчимжүүлж,  
хандивын аян өрнүүлэх тухай

Равданчойнхорлин хийдийн захиргаа, сумын иргэдийн зүгээс сүсэгтэн олны шашин номын эрэлт хэрэгцээг хангах, Монголын уламжлалт зан заншлыг сэргээх, сурталчлах зорилгоор суманд "Равданчойнхорлин" хийдийн хурлын дугана байгуулахаар гаргасан санаачлагыг хэлэлцээд Монгол улсын Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх, Монгол улсын Засаг захиргаа, Нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь, Төр сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Цагаан-Уул сумын нутаг дэвсгэрт "Равданчойнхорлин" хийдийн хурлын дугана байгуулахаар гаргасан саналыг нутгийн бүх иргэдийн тухайн суманд ажиллаж амьдарч байсан хүмүүс, албан газар, аж ахуйн нэгж, Төрийн бус байгууллагын хамтын бүтээл болгон дэмжсүгэй.

2. Засаг дарга /Д.Түмэнбаяр/-д даалгах нь:

2.1. "Равданчойнхорлин" хийдийн хурлын дугана байгуулах ажилд сайн дурын үндсэн дээр хандив өргөх ажлыг сумын нутаг дэвсгэр дэх аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллага, баг, иргэд, сүсэгтэн олонд сурталчилгаа хийх ажлыг зохион байгуулах.

2.2. Нийслэл, аймгийн төв, хот суурин газруудад суурьшиж байгаа, тус суманд ажиллаж, амьдарч байсан хүмүүс, сумын уугуул иргэд, сүсэгтэн олонд "Равданчойнхорлин" хийдийн хурлын дугана байгуулах ажилд оролцохыг уриалж тэдний санал, санаачлагыг дэмжиж ажиллах.

3. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга Л.Сэрсмаад үүрэг болгосугай.

ДАРГА

Ч.АЗБАЯР